



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/512

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага”-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зааврыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлэг болон тусгай эмнэлгийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 12 сарын 14 өдрийн
А/СМ дугаар тушаалын хавсралт

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ХАНДЛАГА”-ЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенц, нэмэлт протоколд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ авах эрхийг хүлээн зөвшөөрч, тэгш боломж бүрдүүлэх талаар тэмдэглэсэн байдаг ба Монгол улс энэ конвенцид 2009 оны 5-р сарын 13-нд нэгдэн орсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчныг бүрдүүлэхэд бүх талуудын идэвхтэй хамтын ажиллагааг дэмжих асуудлыг Дэлхий нийтийн Тогтвортой хөгжлийн зорилтод (2015-2030) онцгойлон дурдсан байдаг.

Түүнчлэн, Ази Номхон далайн бүс нутгийн Төр засгийн тэргүүн нарын чуулга уулзалтаар “Эрхийг бодит болгоё” стратеги (Инчеон стратеги 2013-2022 он) батлагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүний бүх талын эрхийг хамгаалахад Ази Номхон далайн бүс нутгийн улс орнуудын Засгийн газрын үүрэг амлалтыг бодитой болгох чиглэл гарсан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг сайжруулах 2014-2021 оны үйл ажиллагааны дэлхийн стратеги төлөвлөгөө¹ гарсан. Энэ стратеги нь улс, орнуудын эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн үйлчилгээ авахад тулгардаг саад, бэрхшээлийг арилгах, хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлагын хүрээнд сэргээн засах тусламжийг хөгжүүлэх, өргөжүүлэхэд загвар жишээ болгосон байдаг.

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 6 ба 7 дугаар бүлэг² “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх” асуудлыг тусгасан.

Эрүүл мэндийн салбарт 2011 оны Эрүүл мэндийн сайдын 216 дугаар тушаалаар “Тэгш дүүрэн” үндэсний хөтөлбөр (2011-2015 он) батлагдан амжилттай хэрэгжүүлж дууссан.

Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг “Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага”-д тулгуурлан

¹WHO global disability action plan 2014-2021. Better health for all people with disability
<http://www.who.int/disabilities/actionplan/en/>

² “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” 6-р бүлэг, 7 –р бүлгийн 22.1.1

хэрэгжүүлэхэд энэхүү зааврыг эрүүл мэндийн байгууллага, эмч, мэргэжилтнүүдэд зориулан боловсрууллаа.

1.1 Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд сэргээн засах тогтолцоог бүрдүүлэхэд зааврын зорилго оршино.

1.2 Зааврын нэр томъёо

Эрүүл мэнд гэж дан ганц өвчин эмгэггүй байгаад зогсохгүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн сайн сайхан байдлыг цогцоор хэлнэ.

Хамт олон гэж газар зүйн байршлаараа нэг дор амьдардаг, нэг засаг захиргаа, нэг хэл, нийтлэг ашиг сонирхолтой ижил бүлэг хүмүүсийг;

Амьдралын чанар гэж хүний өдөр тутмын үйл ажиллагаанд хэвийн оролцож чадах боломж, чадварыг;

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж бие махбодь, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай хавсарсны улмаас нийгмийн амьдралд бусдын адил бүрэн гүйцэд, үр дүнтэй оролцох боломж хязгаарлагдсан хүнийг;

Урьдчилан сэргийлэх гэж аливаа өвчин эмгэг, гэмтэл, бэртэл, эрсдэл, түүнээс үүдэлтэй эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах, эрт илрүүлэх, эмчилгээнд эрт хамруулах зэрэг орчин нөхцөлийг бүрдүүлж, мэдээлэл, сурталчилгаа явуулах үйл ажиллагааг;

Анхдагч сэргийлэлт гэж эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал, эрсдэлт зан үйл, ус, хоол хүнс, амьдарч байгаа орчны эрсдэлүүдээс хамгаалах, зайлсхийх, дархлаажуулах зэрэг сэргийлэлтийг;

Хоёрдогч сэргийлэлт гэж эрүүл мэнд, өвчин эмгэгийн эрсдэлтэй хүнийг эрт илрүүлэн, даамжруулахгүй эмчлэх, сэргийлснээр эрүүл мэндийн зардал, эмнэлгийн ачааллыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг;

Гуравдагч сэргийлэлт гэж аливаа эмгэг, согог болон архаг өвчнийг даамжралыг хязгаарлах, хүндрэлээс сэргийлэх, тухайн хүний бие даасан байдал, нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн сэргээн засах үйлчилгээг;

Сэргээн засалт гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний алдагдсан ба хязгаарлагдсан үйлдлийг сэргээх болон хүний бие даасан байдал, бусдаас хамааралгүй байдлыг боломжит дээд хэмжээнд хүргэхийг;

Ахуй (хөдөлмөр) засал гэж ахуйн үйл ажиллагаа болон хөдөлмөр эрхлүүлэх аргаар хүний эрүүл мэнд, алдагдсан чадварыг сэргээхийг;

Хөдөлгөөн засал гэж хөдөлгөөний чадавхийг тодорхойлж, чадвар алдалтаас урьдчилан сэргийлж, эмчилж хүний эрүүл мэнд, алдагдсан чадварыг сэргээхийг;

Хэл засал гэж хэл ярианы согог, дультраа хэллэг, ярианы тод байдал алдагдсан үед ярих чадварыг засахыг;

Сэтгэл засал гэж сэтгэцийн эмгэг /түгшүүр, сэтгэл гутрал, гэмтлийн дараах стрессээс үүдэлтэй эмгэг гэх мэт/ болон зан үйлийн эмгэг /түрэмгий байдал, цочмог зан, хор хохирол учруулах үйлдэл гэх мэт/-тэй хүмүүст ярилцлага болон бусад аргаар эмчилгээ хийхийг;

Чадвар алдалт гэж биеийн үйл ажиллагааны аливаа үйлдэл хийж чадахгүй болох нөхцлийг;

Туслах хэрэгсэл гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл үүсэхээс сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

Эрт илрүүлэлт гэж зорилтот бүлгийн эрүүл хүн амыг эрүүл мэндийн нэгдсэн үзлэг, шинжилгээнд хамруулж өвчин эмгэгийн эрсдэлтэй хүнийг олж, илрүүлэн цаашид нарийвчилсан оношилгоо, шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах арга хэмжээг тус тус хэлнэ.

Хоёр.Хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлага

Хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлага нь гарал угсаа, арьс өнгө, шашин шүтлэг, нас хүйс, улс төрийн итгэл үнэмшил, эдийн засаг болон нийгмийн байдлаас үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй хүний үндсэн хэрэгцээнд нийцүүлэх, ойлголт, ухамсрыг дээшлүүлэх, тэгш хамралтыг дэмжих, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг сайжруулах үндсэн зорилготой.

2010 онд хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлагыг салбар хоорондын уялдаа холбоонд тулгуурлан ерөнхий зураглалыг (матриц) ДЭМБ, ОУХБ, ЮНЕСКО, ХБХК хамтран боловсруулсан. Энэ зураглал нь эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн, эрх мэдэлжүүлэх гэсэн таван бүрэлдэхүүнтэй. Үүнээс улс орнууд өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохирсон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх аргачлал өгсөн байдаг.

Бүрэлдэхүүн тус бүр таван элементтэй. Эхний дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нь хөгжлийн үндсэн салбаруудтай холбоотой, харин 5 дахь бүрэлдэхүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, амьдралын чанарыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл, хамт олны оролцоог бэхжүүлж, эрх мэдэлжүүлэхтэй холбоотой.

Хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлага Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг "Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага"-аар хэрхэн үзүүлэх талаар энэ зааварт тусгасан болно.

2.1Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг

Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэгт дараах чиглэлүүд хамаарна. Үүнд:

1. Эрүүл мэндийг дэмжих
2. Урьдчилан сэргийлэх
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх
4. Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх
5. Туслах хэрэгслийн талаарх мэдээлэл өгөх

2.1.1 Эрүүл мэндийг дэмжих:

2.1.1.1 Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг хүн амын насны бүлэг, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл, тодорхой өвчин эмгэг, оршин суугаа байрлал гм бүлэглэн зохион байгуулах, нийтэд зориулсан сурталчилгаатай ижил утга санаа, үг хэллэгтэй, өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн хийсэн байх;

2.1.1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах, эмчилгээ, заслын үр дүн, эрсдэл, эрүүл мэндийн эрхээ эдлэх талаар мэдлэг олгох, мэдээллээр хангах;

2.1.1.3 Сэргээн засах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, шийдвэр гаргахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамт олны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндээ дэмжих үйл ажиллагаанд оролцоход нь дэмжлэгт орчин бүрдүүлэх;

2.1.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний гэр бүлд эрүүл мэндээ хамгаалах дадал хэвшил, зөв зан үйл эзэмшүүлэх, мэдээллээр хангах, асуудлаа бие даан шийдвэрлэхэд дэмжих, эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулах;

2.1.1.5 Үйлчлүүлэгчийн чадавх, мэдлэг, ур чадварыг сайжруулах үйл ажиллагаа явуулах, өөрсдийн эрүүл мэнд, бэрхшээлийг хянан зохицуулах чадвартай болгох;

2.1.1.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдийн өвөрмөц хэрэгцээнд үнэлгээ хийх, хөдөлгөөний чадвар алдалтын хэлбэр, зэрэг, орчны хүчин зүйлд тохирсон сэргээн засах үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх;

2.1.1.7 Хөгжлийн бэрхшээл үүсэхээс сэргийлэх, гэр бүл, хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын талаар эрүүл мэндийн байгууллага, олон нийтийн нэгдсэн ойлголтыг бий болгох;

2.1.1.8 Эмнэлгийн мэрэгжилтнүүд хөгжлийн бэрхшээлийн өвөрмөц байдалд тохируулан үйлчлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхлаас ангид байхад чиглэсэн харилцаа хандлагыг эзэмших;

2.1.1.9 Эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааны цахим хуудсыг хялбар, энгийн бүтэцтэй, хялбаршуулсан зураг, дүрслэл бүхий тайлбартай, харааны болон сонсголын бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл авах боломжтой байхаар хийх;

2.1.1.10 Харааны бэрхшээлтэй хүмүүст сурталчилгааны материалыг том үсгээр хэвлэх, брайл үсгээр бичсэн мэдээлэл сурталчилгааны материалыг хэвлэх, сүүлийн үед хэрэглэгдэж байгаа дуут ном, сургалтчилгааны дэлгэц ашиглах;

2.1.1.11 Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл сурталчилгааны материалыг зураг, тэмдэг зэрэг ойлгомжтой дүрст тайлбар ашиглах.

2.1.2 Урьдчилан сэргийлэх

2.1.2.1 Анхдагч урьдчилан сэргийлэлт хийх: эрсдэлт зан үйл, ус, хоол хүнс, амьдарч байгаа орчны эрсдэлээс хамгаалах, тэдгээрээс зайлсхийх асуудлууд орох ба энэ ажлын хүрээнд:

Ураг, нярай, бага насны хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс сэргийлэх: эрсдэлт хүчин зүйлүүдийг судлах, хөгжлийн бэрхшээл үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа тогтмол зохион байгуулах;

2.1.2.2 Хоёрдогч сэргийлэлт: өвчин үүсгэгч эрсдэлт хүчин зүйлс байгаа эсэхийг эрт илрүүлэх, эрсдэлийг бууруулах, илэрсэн өвчнийг эрт үед нь оношлох даамжруулахгүй эмчлэх, сэргийлэх асуудлууд орох ба үүнд:

1. Нярай болон бага насны хүүхдийг нэгдсэн үзлэг шинжилгээнд хамруулж эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх;
2. Үзлэгээр илэрсэн эрсдэлтэй хүүхдийг нарийвчилсан үзлэг, шинжилгээгээр баталгаажуулах (сонсгол, хараа, сүрьеэ г.м бие махбодын эмгэг, өвчин болон хөгжлийн хоцрогдлыг хамт илрүүлнэ);

2.1.2.3 Гуравдагчурьдчилан сэргийлэлт: аливаа эмгэг, согог болон архаг өвчнийг даамжралыг хязгаарлах, хүндрэлээс сэргийлэх; Үүнд: Хэвтрийн болон суунги байдлаас арьс цоорох, шээсний замын халдвар үүсэх, үений хөдөлгөөн хязгаарлагдах, яс сийрэгших, сэтгэл гутралд орох зэргээс сэргийлэх талаар эрүүл мэндийн ажилтнууд болон гэр бүлийг сургах, тэднийг нийгмийн амьдралд оролцуулах зорилготой сэргээн засалтын үйлчилгээ үзүүлэх, туслах хэрэгслийн талаарх мэдээллээр хангах;

2.1.2.4 Эцэг эх, гэр бүлд хүүхдийн хөгжлийн хоцрогдол болон хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж хөгжлийн дэмжлэг үзүүлэх талаар мэдлэг олгох;

2.1.2.5 Стандарт асуумж сорилоор хүүхдийн хөгжлийг үнэлэхэд өрх, сум, багийн эмч цэцэрлэгийн багш нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах;

2.1.2.6 Хүн амын дунд хөгжлийн бэрхшээлийн эрсдэлээс сэргийлэх мэдлэг, мэдээллийг өгөх, нэгдсэн ойлголтоор хангаж хамтарч ажиллах.

2.1.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2.1.3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн цаг товлох үйлчилгээг уян хатан болгох, үзлэг, шинжилгээг тухайн өдөрт нь багтаах, олон дахин явуулахгүй байхаар зохицуулахыг эрүүл мэндийн байгууллагын дотоод журмаар зохицуулж өгөх;

2.1.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эмнэлэгт үзүүлэхэд харшил, эмийн дасал болон бусад анхаарах мэдээллийг үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн дэвтрийн эхний нүүрэнд тодорхой бичих;

2.1.2.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хийгдэх эмчилгээг өөрт нь, эсвэл асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдэд заавал танилцуулах, тайлбарлаж өгөх;

2.1.3.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүний оношилгоо, эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслээр хангагдах, хүний нөөцийг чадавхжуулах (хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ор, сандал, таяг өлгөх дэгээ, бариул гм);

2.1.3.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүний өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд дараах харилцаа, хандлагыг анхаарна. Үүнд:

А.Нийтлэг

1. Тэдний өвөрмөц хэрэгцээнд ямар тусламж шаардлагатай байгааг нэг бүрчлэн заавал асуух, анхааралтай сонсох, хэрэв тусламж, үйлчилгээг шийдэж чадахгүй байвал үйлчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө зааж өгөх боломж олгох;

2. Тусламж, үйлчилгээний хэлбэр, харилцааны аргыг өөрөөр нь сонгуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өөрийн эрүүл мэнд болон өвчний шинж тэмдгийн талаар ярихад анхааралтай хүлээцтэй сонсох, үйлчлүүлэгчийн нүүрний түвшинд харилцах, зөвхөн үйлчлүүлэгчийн хүсэлтээр хамт яваа хүнтэй эмчилгээний асуудлыг ярилцах;

3. Тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэл өгөх, ижил асуудалтай хөгжлийн бэрхшээлтэй хүний эмчилгээний туршлагатай танилцах боломж олгох;

Б. Харааны бэрхшээлтэй хүнтэй харилцах

1. Наашаа суу гэж хэлж болохгүй. Учир нь таныг хаана сууж байгаа, урд нь юу байгааг харж чадахгүй.

2. Харааны бэрхшээлтэй хүнд туслахын тулд гэнэт гарнаас нь хөтлөөд явж болохгүй. Өмнө нь зогсоод гарыг нь мөрөн дээрээ тавьж эсвэл тохойноос тань барьж баримжаагаа авдаг.

3. Өмнө нь байгаа саадыг тайлбарлаж өгнө.

4. Таныг сайн сонсох учир хүндээ ойртож чангаар ярих хэрэггүй.

5. Аливаа бичсэн зүйлийг уншиж тайлбарлаж өгнө.

В. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнтэй харилцах.

1. Масктай ярьж, харилцаж болохгүй.

2. Нүд рүү нь харж байгаад үгээ тод, удаан ярина. Сонсголын бэрхшээлтэй ихэнх хүн амны хайрцгаар уншиж чаддаг.

3. Ярьж байгаад гэнэт босоод явж болохгүй. Учир нь (жишээ нь хаалга тогшихыг) тантай харилцаж байгаа хүн эргэн тойрны дуу чимээг сонсч чадахгүй.

4. Гэнэт араас нь хараагүй байхад нь найзархаж нуруун дээр нь алгадаж болохгүй.

Г. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүнтэй харилцах

1. Тэргэнцэртэй хүнтэй харилцахдаа түүний харааны түвшинд харилцана. Зогсож ярихад тэргэнцэртэй хүн таны гэдсийг харахад хүрдэг.

2. Тэргэнцрийг гэнэт түрж болохгүй. Гэнэт орхиж явж болохгүй. Заавал анхааруулж байх хэрэгтэй.

3. Тэргэнцэр тухайн хүний биеийн нэг хэсэг болсон байдаг. Тиймээс тэргэнцэрээс цүнхээ өлгөж, хөлөө тавьж болохгүй.

4. Тэргэнцэртэй хүнийг тэргэнцэртэй нь шууд өргөж болохгүй. Шатаар буулгах, өргөхдөө буруу харуулж өргөж болохгүй. Хүндийн жингээр нь тулан буулгах хэрэгтэй.

Д. Унадаг татдаг бэрхшээлтэй хүнтэй харилцах

1. Гэнэт араас нь хараагүй байхад нь найзархаж нуруун дээр нь алгадаж болохгүй. Цочсоны улмаас унаж, татаж болно.

Е. Оюуны ухааны буюу сурах бэрхшээлтэй хүнтэй харилцах

1. Энгийн үг хэллэг хэрэглэж ярина.

2. Удаан ярилцах, ойлгохыг хичээх хэрэгтэй.

2.1.4. Сэргээн засах тусламж, үйлчилгээ

2.1.4.1 Сэргээн засах тусламж үйлчилгээг анхан, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллага, гэр бүл, хамт олны хүрээнд дараах чиглэлээр үзүүлнэ. Үүнд:

2.1.4.2 Хөдөлгөөн засал

1. Насжилт, гэмтэл, өвдөлт, өвчлөл, эмгэг, орчны хүчин зүйлээс үүдэлтэй хөдөлгөөн хязгаарлагдсан үед хөдөлгөөний хэвийн үйл ажиллагаанд оруулах засал хөдөлгөөн хийх;

2. Өвчний болон бусад шалтгааны улмаас /тархины харвалт, нуруу нугасны гэмтэл, тархины саа өвчин, осол гэмтэл /хөдөлгөөн хязгаарлагдсан хүнд алдагдсан чадварыг сайжруулах идэвхтэй болон идэвхгүй дасгал хөдөлгөөн хийлгэх, заах, дадлагажуулах;

3. Хөдөлгөөн засалч хөдөлгөөний боломжит түвшинг тогтоох;

4. Хөдөлгөөн засал эмнэлэг, гэр, гэр бүл, хамт олонд түшиглэх.

2.1.4.3 Хөдөлмөр засал буюу ахуй засал

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний гамьдралын өдөр тутмын үйл ажиллагааг хийх чадвартай болгож сэргээх олон төрлийн сургалт /хувцсаа өмсөх, товчлох, үсээ самнах, нүүр гараа угаах гм/ явуулах;

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэж байгаа, тэдэнд хэрэгтэй, хийхээр төлөвлөж байгаа ажлыг хийх чадварыг ахуй засалааргэрийн орчинд тулгуурлан сэргээх, дасгал хийлгэх, гэр бүл, хамт олонд түшиглэн явуулах.

2.1.4.4 Хэл засал

1. Хүүхэд, насанд хүрэгчдийн хэл яриа, үг хэллэгийн чадвартай холбоотой үйл ажиллагааг засах;

2. Хэл ярианы бэрхшээлийг эрт илрүүлэх, хэл засалд хамруулах;
3. Гэр бүл, хамт олонд түшиглэсэн хэл засал, сэргээн засалтыг явуулах.

2.1.4.5 Сувилахуй

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах, сэргээх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд өөрийгөө арчлах ур чадварыг хөгжүүлэх, гэр бүлийн гишүүдэд сувилахуйн арга барилыг заах.

2.1.4.6 Өөрийгөө арчлах бие даалгах үйл ажиллагаа:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хувийн ариун цэвэр сахих, эрүүл ахуйн дадал эзэмшүүлэх;
2. Гэр бүл, ахуйн зан үйлд дадлагажуулах;
3. Хамт олонд түшиглэсэн үйл ажиллагаанд оролцуулах, нийгэмд бусадтай хамт ажиллах, амьдрахад чиглүүлэх.

2.1.4.7 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх:

1. Ганцаарчилсан зөвлөгөө өгөх, ярилцах;
2. Стресс, бухимдлаа тайлах, тайвшрах дасгал заах;
3. Нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх, хамт олонд түшиглэсэн засал, сургалт явуулах.

2.1.5. Туслах хэрэгсэл

2.1.5.1 Туслах хэрэгсэл нь энгийн буюу өндөр технологийн бус өдөр тутмын (таяг, зориулалтын аяга гм) хэрэгсэл, өндөр технологээр бүтээсэн хэрэгсэл (компьютерийн тусгай програм болон техник хангамж, мотортой тэргэнцэр гм) байна. Үүнд нийтлэг хэрэглэгддэг дараах туслах хэрэгслүүдийн талаарх мэдээллийг өгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зуучилж өгнө. Үүнд:

1. Хөдөлгөөн дэмжих хэрэгсэл
2. Байрлуулах хэрэгсэл
3. Протез, ортоз, ортопед гутал
4. Өдөр тутмын хэрэгсэл
5. Харааны хэрэгсэл
6. Сонсголын хэрэгсэл
7. Танин мэдэхүйн хэрэгсэл
8. Харилцааны хэрэгсэл

2.1.5.2.1 Хөдөлгөөн дэмжих хэрэгсэл:

Хөдөлгөөн дэмжих хэрэгсэл нь хэрэглэгчийн хэрэгцээнд тохируулдаг онцлогтой байж болно. Тухайлбал, тархины саатай хүнд түүнийг зөв суухад зориулж цээж/толгойн түшлэгтэй тэргэнцэр шаардлагатай байж болно. Үүнийг гар доорх материал ашиглан хийлгэж болдог.

1. Тэргэнцэр
2. Гурван дугуйт
3. Суга, тохой таяг

4. Таяг/Цагаан таяг

5. Алхуулагч

2.1.5.2.2 Байрлуулах хэрэгсэл

Хөдөлгөөний бэрхшээлтэй хүнд хэвтэх, босох, суух үйлдэл хийхэд хүндрэлтэй байдгаас эсвэл буруу байрлалаас болж гажиг үүсэх эрсдэлтэй байдаг. Дараах хэрэгслүүд зарим хүндрэлийг давахад туслана:

1. Налуу тавцантай ор (хүүхдэд зориулсан)
2. Сандал (булангийн сандал, тусгай суудал)
3. Зогсоох хэрэгсэл

2.1.5.2.3 Протез, ортоз, ортопед гутал

Энэ нь хүний биеийн хэсгүүдийг засах, дэмжих, орлуулахын тулд захиалгаар хийгддэг хэрэгсэл юм. Тусгай төвд, бэлтгэгдсэн мэргэжилтнүүд зохиож, үйлдвэрлэж, тааруулдаг хэрэгслүүд:

1. Протез: хиймэл хөл, гар
2. Ортоз: хөл, гар, нуруу, хүзүүний чиг, дөрөөвч, хөл, гарын тугор, өлмий өргөгч, эрхий хуруу салгагч гм
3. Ортопед: (гажигтай хөлөнд таарсан) гутал

2.1.5.2.4 Өдөр тутмын хэрэгсэл

Энэ нь өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг (идэх, усанд орох, хувцаслах, бие засах, орон гэрийг засах) гүйцэтгэх боломжтой болгох хэрэгсэл юм. Үүнд:

1. Зориулалтын гал тогооны хэрэгсэл, аяга
2. Шүршүүрт хэрэглэх сандал
3. 00-ийн суултуур ба түшлэг
4. Шүүгээ
5. Хувцасны өлгүүр гм

2.1.5.2.5 Харааны хэрэгсэл

Хараа муу, эсвэл хараагүй байх нь хүний амьдралын чухал үйл ажиллагааг хийх чадварт шууд нөлөөлдөг. Доорх энгийн, нарийн хэрэгслүүд нь нийгмийн оролцоо болон бие даасан байдлыг нэмэгдүүлдэг:

1. Том үсгээр хэвлэсэн ном
2. Томруулагч шил
3. Нүдний шил
4. Цагаан таяг
5. Унших, бичихэд хэрэглэдэг Брайл систем
6. Дуу бичлэгийн хэрэгсэл, жишээ нь: радио, ярьдаг ном, гар утас (Daisy програм),
7. Компьюетрийн дэлгэц унших програм (тухайлбал дэлгэц уншигч JAWS програм)

2.1.5.2.6 Сонсголын хэрэгсэл

Сонсголоо алдах нь бусадтай харилцах хэл ярианд өөрчлөлт өгч сурах, ажиллах, нийгэмших боломжийг хязгаарлаж хүний үйлдлийн олон үйл ажиллагаанд

нөлөөлдөг. Сонсголын хэрэгслүүд нь:

1. Сонсголын аппарат
2. Чихэвч
3. Утасны өсгөгч
4. Харилцаа холбооны хэрэгсэл
5. Харааны системээр дохио өгөх. жишээ нь: хонх дуугарахад гэрэл асах гм

2.1.5.2.7 Харилцааны хэрэгсэл

Ойлгох болон ярихад хүндрэлтэй хүнд харилцааны хэрэгсэл тус болдог. Ярихад туслах эсвэл хэл яриаг орлуулах хэрэгсэл нь:

1. Зураг, тэмдэгт, цагаан толгойн үсэгтэй харилцах самбар
2. Хүсэлтийн картууд
3. Дуу хоолойг гаргах төхөөрөмж
4. Тусгай тоног төхөөрөмж болон програмаар тоноглогдсон компьютер

2.1.5.2.8 Танин мэдэхүйн хэрэгсэл

Танин мэдэх нь мэдээллийн үйл явц ба ойлгох чадвар юм. Үүнд санах, төлөвлөх, асуудал шийдвэх зэрэг тархины сэтгэцийн үйлдлүүд багтана. Тархины гэмтэл, оюуны бэрхшээл, солиорол, дэмийрэл болон сэтгэцийн өвчнүүд нь хувь хүний танин мэдэхүйн чадварт нөлөөлдөг. Дараах хэрэгслүүд нь цаг төлөвлөх, чухал үйл явдлыг санах, үйл ажиллгаанд бэлтгэхэд тус болно:

1. Жагсаалт гаргах
2. Өдрийн тэмдэглэл
3. Хуанли
4. Хуваарь
5. Гар утас, пэйжэр, хувийн зохион байгуулагч зэрэг цахим хэрэгслүүд

Гурав. Эрүүл мэндийн мэргэжилтний оролцоо

3.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч

1. Өрхийн эрүүл мэндийн төвийн ахлах эмч нь Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг зохион байгуулах зохицуулагч байна;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг эрт илрүүлэх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж, үйлчигээний хэрэгцээг тодорхойлох;
4. Хамрагдах нутаг дэвсгэрт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байршлын зураглалыг гаргах;
5. Хэрэгцээт үйлчилгээнд зуучлах /лавлагаа шат, сувилал, сэргээн засалтын эмчилгээнд илгээх, туслах хэрэгсэл хийлгэх, ерөнхий боловсролын сургуульд ороход нь зуучлах, ажил хөдөлмөртэй болоход нь зөвлөгөө өгөх, сургалтанд хамруулах, хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэгийн үйлчилгээ, насан туршийн боловсрол, протез, ортопедийн үйлчилгээ/;

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд болон түүний гэр бүлийн гишүүдэд гэрийн нөхцөлд хийх сэргээн засалтын дасгал хөдөлгөөнийг зааж өгөх;
7. Анхдагч, хоёрдогч хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх;
8. Дасгал хийж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол хянах, ахиц дэвшлийг үнэлэх;
9. Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн сургалт зохион байгуулах.

3.2 Сумын эрүүл мэндийн төвийн эмч, багийн эмч

1. Сумын эрүүл мэндийн төвийн их эмч нь Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг зохион байгуулах зохицуулагч байна;
Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрт илрүүлэх;
2. Өөрийн хариуцсан нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байршлын зураглалыг гаргах;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн туслэмж, үйлчигээний хэрэгцээг тодорхойлох;
4. Хэрэгцээт үйлчилгээнд зуучлах /лавлагаа шат, сувилал, сэргээн засалтын эмчилгээнд илгээх, туслах хэрэгсэл хийлгэх, ерөнхий боловсролын сургуульд ороход нь зуучлах, ажил хөдөлмөртэй болоход нь зөвлөгөө өгөх, сургалтанд хамруулах, хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэгийн үйлчилгээ, насан туршийн боловсрол, протез, ортопедийн үйлчилгээ/;
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлийн гишүүдэд гэрийн нөхцөлд хийх сэргээн засалтын дасгал хөдөлгөөнийг зааж өгөх;
6. Анхдагч, хоёрдогч хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх;
Дасгал хийж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол хянах, ахиц дэвшлийг үнэлэх;
7. Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн сургалт зохион байгуулах.

3.3 Сэргээн засалч эмч, мэргэжилтэн

1. Сэргээн засалтын үйлчилгээг үзүүлэх;
2. Өрх, сумын эмч, хөдөлгөөний бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлийн гишүүдэд сэргээн засалтын мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх;
3. Хоёрдогч, гуравдагч хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх, эмчлэх;
4. Гэрийн нөхцөлд хийх дасгал хөдөлгөөнийг хувь хүнд болон гэр бүлийн гишүүдэд зааж өгөх;
5. Дасгал хийж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол хянах, ахиц дэвшлийг үнэлэх;
6. Мэргэшлийн эмч, мэргэжилтнүүдэд зуучлах;
7. Мэргэжлийн сургалт зохион байгуулах.

3.4 Хөдөлгөөн засалч

1. Хөдөлгөөний чадварын байдлыг үнэлж, сэргэх боломжийг тодорхойлох, үнэлэх;
2. Сэргээн засах эмчилгээний төлөвлөгөөг хувь хүн бүр дээр боловсруулах;
3. Сэргээн засах эмчилгээнд өвчтөн, гэр бүлийнхнийг оролцуулах;
4. Мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх;
5. Гэр бүлийнхэнд сургалт зохион байгуулах;
6. Дасгал хийж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол хянах, ахиц дэвшлийг үнэлэх.

3.5 Сэтгэл засалч

1. Хувь хүн бүрийн онцлогт тохирсон сэтгэл заслын эмчилгээ хийх;
2. Бусад мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах;
3. Заавар, зөвлөгөө өгөх.

3.7 Нийгмийн ажилтан

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, гэр бүлийн гишүүдийг мэдээллээр хангах;
2. Хэрэгцээт үйлчилгээнд хамрагдахад нь туслах, зуучлах;
3. Гэр бүлийн гишүүдэд зөвлөх, туслах.

3.8 Ахуй (хөдөлмөр) засалч

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын үйл ажиллагааны чадварыг үнэлэх;
2. Саад болж байгаа хүчин зүйлийг тодорхойлох: мэдрэхүй-хөдөлгөөний, танин мэдэхүйн, хүрэлцэхүйн, сэтгэц нийгмийн гм;
3. Өөртөө үйлчлэх чадвар (нүүрээ угаах, хувцаслах, хооллох гм), гэр орны ажил (дэлгүүр явах, хоол хийх, цэвэрлэх), ажил хөдөлмөр эрхлэх болон чөлөөт цагаа өнгөрүүлэх чадварыг үнэлэх;
4. Нийгмийн гадаад орчинг үнэлэх (гэр бүлийн байдал, найз нөхөд, хамаатан садан);
5. Хүрээлэн байгаа гадаад орчныг үнэлэх (орон байрны байдал, ажилын байр гм);
6. Үнэлгээнд тулгуурласан ахуйн/хөдөлмөр заслыг хүн бүрт тусгайлан хийх, өөрт нь болон гэр бүл, асран хамгаалагчид заах, дадлагажуулах;
7. Өвчтөнг бие даахад туслах, зөвлөгөө өгөх.

3.9 Сургуулийн эрүүл мэндийн ажилтан

1. Бага ангийн хүүхдүүдийн дунд хөгжлийн бэрхшээл илрүүлэх үзлэг зохион байгуулах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;
2. Сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, түүний эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
3. Хүүхдийн хамт олонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харьцах, хүндлэх, ойлгох, туслах харилцааг төлөвшүүлэх, мэдээллээр хангах, үйл ажиллагаа зохион байгуулах;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгайлсан хэрэгцээ, бэлгийн бойжилтын үеийн онцлогийн талаарх зөвлөгөө өгөх.

3.10 Сургуулийн нийгмийн ажилтан

1. Сургуулийн хүүхдийн дунд хөгжлийн бэрхшээл, нийгмийн оролцооны талаарх мэдээлэл өгөх, ялгаварлан гадуурхахын эсрэг үйл ажиллагаа зохион байгуулах;
2. Сургуулийн гадаад, дотоод орчныгхөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй болгох, мэдээллээр хангах;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамт олонд түшиглэн нийгмийн харилцаанд идэвхтэй болгох, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, амьдрах ухаанд бэлтгэх;
4. Эцэг эхчүүдэд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх, зөв хандлага бий болгоход үйл ажиллагаа зохион байгуулах.

3.11 Цэцэрлэгийн эрүүл мэндийн ажилтан

1. Хүүхдийн хөгжлийн өдөр тутмын үйл ажиллагааны чадварыг үнэлэх;
2. Хүүхдийн хөгжилд саад болж байгаа хүчин зүйлийг тодорхойлох: мэдрэхүй-хөдөлгөөний, танин мэдэхүйн, хүрэлцэхүйн, сэтгэц нийгмийн гм;
3. Тохирох эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх (дасгал, хөдөлгөөнийг хийх);
4. Эцэг эхчүүдэд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх, зөв хандлага бий болгоход үйл ажиллагаа зохион байгуулах;
5. Хүүхдийн гадаад орчны үнэлгээ хийх, ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөгөө гаргах;
6. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд илгээх, хамтран ажиллах.

3.12 Үйлдвэр, байгууллагын эрүүл мэндийн ажилтан

1. Ажилтны дунд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг илрүүлэх;
2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар заавар, сургалт зохион байгуулах;
3. Байгууллагын ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх, зөв хандлага бий болгоход үйл ажиллагаа зохион байгуулах.

Дөрөв. Үйлчлүүлэгчийн өвчин, эмчилгээний нууцыг хадгалах

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн талаарх нууц, эмзэглэх асуудлыг зөвшөөрөлгүйгээр гуравдахь этгээдтэй ярилцах, мэдээлж болохгүй;
2. Зайлшгүй нөхцөлд гэр бүлийн гишүүд, итгэмжлэгдсэн хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцаж хэлмэрчилж өгөхийг хүсч болно;
3. Эцэг эхэд нь хүүхдээр хэлмэрчлүүлэхээс аль болох зайлсхийх.

Тав. Товчилсон үгийн жагсаалт

НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллага
АИФО	Раул Фолерогийн анд нөхдийн холбоо – Италийн төрийн бус байгууллага /AIFO/
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХК	Хөгжлийн бэрхшээл ба хөгжлийн олон улсын консорциум /IDDC/
ХОТСЗ	Хамт олонд түшиглэн сэргээн засах
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн